



## СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

### Г Ур чадварын нэмэгдэл олгох журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/166-А/63-А/73 дугаар тушаал, Соёлын өвийн үндэсний төвийн дүрмийн 3.3.6 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 10.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний төвийн албан хаагчид “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (А. Ганбат)-т даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2019 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/07 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсугай.



1724010119

# مەن مەن مەن مەن مەن

بەشىرىتىقۇل ئەم

فەنسىز بەر

بەر و بەر بەر

بەر) عەھەد نەم بىرىقىز بېتىقسو

ئەممۇن و فەمىسىن مەسسىز

بەنەسىنەد نەم مەسسىز بەنەسىنەد 706 فەنسىز مەن مەن 706 قىرب نەستا . مەنەن نەم سىئەن و مەسسىز بەنەسىنەد 706  
 فەنسىز مەن مەن 706 قىرب نەتسىپ . سىئەن نەسسىنەد 760U بەر و 760U فەنسىز مەن مەن 760U فەنسىز بەنەنىڭ  
 «مەنەن نەم بەنەنىڭ و سىئەن نەتسىپ . بەر) عەھەد نەم بىرىقىز بېتىقسو نەتىجىنى تىلىم» . بەنەنىڭ مەن مەن .  
 بەنەنىڭ . نەتسىپ . نەتسىپ مەن بەنەنىڭ . بەنەنىڭ مەن مەن مەن مەن مەن 760U بەر و «بېتىقىز بەنەنىڭ و فەمىسىنەد  
 مەسسىز» ۷۶۰/۴-۷۶۰/۵-۷۶۰/۶-۷۶۰/۷ فەنسىز بەنەنىڭ . بەنەنىڭ مەن مەن مەن مەن مەن مەن 760U بەر و  
 بەنەنىڭ . بەنەنىڭ نەتسىپ سىئەن نەم 706 قىرب نەتسىپ دە ئەغا ئەغا بەنەنىڭ و فەمىسىنەد بەنەنىڭ نە:

6 .. بەندىھەم و مەنەن نەم سىئەن نەتسىپ «بەر) عەھەد نەم بىرىقىز بېتىقسو تىلىم» - د بەنەنىڭ و فەمىسىنەد ..

7 .. نەتسىپ مەن بەنەنىڭ قو نەپەم سىئەن سىئەن بەنەنىڭ نەتسىپ (د . ئەسۋەنەو) - ۷  
 بېتىقىز بەنەنىڭ ..

8 .. بەر) مەن بەنەنىڭ و فەمىسىنەد مەن بەنەنىڭ بەنەنىڭ بەنەنىڭ مەن بەنەنىڭ و فەمىسىنەد مەن مەن 760U بەر و  
 «بېتىقىز بەنەنىڭ و فەمىسىنەد مەسسىز» بە/0/۷ فەنسىز بەنەنىڭ بەنەنىڭ و فەمىسىنەد مەن بەنەنىڭ ..



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын  
2024 оны 04 дугээр сарын 11-ний өдрийн  
1123. дугаар тушаалтын хавсралт

УЛААНБААТАР ХОТ  
9104208 ХНТ1839  
1118155933

## УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Соёлын өвийн үндэсний төвийн ажилтны ажил гүйцэтгэх ур чадвар, идэвх санаачилгыг дэмжиж, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор ур чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоож, үнэлэх, нэмэгдэл олгоход энэхүү журмаар зохицуулна.

1.2. Ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан байдлыг харгалзан ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй ажилтанд шалгуур үзүүлэлтийг баримтлан ур чадварын нэмэгдлийг олгоно.

1.3. Тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ажилтны ур чадварын нэмэгдлийг улирлаар тогтоож, үндсэн цалингийн 10-25 хүртэл хувиар тооцож сар бүр олгоно.

1.4. Ур чадварыг үнэлж, дүгнэх, нэмэгдэл олгох үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтална.

### ХОЁР УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1. Удирдах албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт

(Хавсралт 1)

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Манлайлах ур чадвар	Газар, нэгжийн үйл ажиллагааг оновчтой зөв удирдан зохион байгуулсан байдал	10	50
		Ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	10	
		Авьяас билэг, ур чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	10	
		Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт	10	
		Төсөв, санхүү, эд хөрөнгийн зөрчилгүй байх	10	
2	Мэргэжил, арга зүйн чадвар	Эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	30
		Мэдлэг, туршлагаа хуваалцах чадвар	10	
		Ажилтны мэргэжил, ур чадварыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилт	10	
3	Ажлын арга барил, асуудал шийдвэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж асуудал шийдвэрлэсэн байдал	10	20
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	10	

2.2. Гүйцэтгэх албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт

(Хавсралт 2)

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Авьяас билэг, мэргэжлийн ур чадвар, туршлагаа хөгжүүлж бусдад үлгэрлэн, түгээсэн байдал	20	60
		Бүтээлч, шинэлэг санаачилга гаргасан байдал, хэрэгжилт, үр дүн	20	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, дутагдал гаргаагүй байх	20	
2	Ажлын арга барил	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж асуудал шийдвэрлэсэн байдал	10	40
		Ажлын гүйцэтгэлд гарсан ахиц, үр дүн	10	
		Иргэд, байгууллагад үзүүлсэн төрийн үйлчилгээний чанар	10	
		Хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	10	

2.3. Үйлчилгээний туслах ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт

(Хавсралт 3)

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хэрэгжилт	40	100
		Идэвх санаачилгатай ажилласан байдал	30	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	30	

2.4. Ур чадварын нэмэгдэл тооцох үнэлгээ, хувь хэмжээ

№	Нийт үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	90-100	25 хувь
2	80-89	20 хувь
3	70-79	15 хувь
4	60-69	10 хувь

2.5. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60 болон түүнээс дээш оноо авсан албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгоно.

ГУРАВ. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЛИЙГ ОЛГОХ

3.1 Үндэсний төвийн захирал газар, нэгжийн даргыг, газар, нэгжийн дарга өөрийн харьяалах ажилтны улирлын ажлын үр дүнг үндэслэн дараа улиралд олгох ур чадварын нэмэгдлийн хэмжээг шалгуур үзүүлэлтээр тогтооно.

3.2 Үндсэн ажилнаар томилогдсон ажилтны ур чадварын нэмэгдлийг түүнийг томилсон тушаалд тусгах бөгөөд дараагийн улирлын ур чадварын нэмэгдлийг тогтоох хүртэл хугацаанд олгоно.

3.3 Ажилтны ур чадварын нэмэгдлийг тухайн улирлын сүүлийн сарын 20-ны дотор шалгуур үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээнд үндэслэж тогтооно. (Журмын 1,2,3 дугаар хавсралт)

3.4 Архив, бичиг хэргийн ажилтан үнэлгээний дүнг нэгтгэн тушаалын төслийг бэлтгэж, Захиргаа, удирдлагын газрын дарга хянаж, Үндэсний төвийн захирал шийдвэрлэнэ.

3.5 Үнэлгээг албан хаагчид танилцуулсан байна.

3.6 Ажилтан ур чадварын нэмэгдэл олгох үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд Үндэсний төвийн захирал шийдвэрлэнэ.

#### ДӨРӨВ. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХГҮЙ БАЙХ ҮНДЭСЛЭЛ

4.1.Шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноо 60 хүрэхгүй бол,

4.2. Туршилтаар ажиллах хугацаанд,

4.3. Үндэсний төвийн захирлын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчид тушаалд заасан хугацаанд.

---оо---

## УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

/Удирдах албан тушаалтан/

Хугацаа: .....

№	Шалгуур үзүүлэлт	Манлайлах ур чадвар					Мэргэжил, арга зүйн чадвар			Ажлын арга барил, асудал шийдвэрлэх чадвар		Нийт оноо, хувь	
		1	2	3	4	5	6	7	8	9	10		
1	Ажилтны нэр	Газар, нэгжийн үйл ажиллагааг оновчтой зөв удирдан зохион байгуулсан байдал	Ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	Авьяас билэг, ур чадва, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан ёврчлэлт	Төсөв, санхүү, эд хөрөнгийн зөрчилгүй байх	Эрхэлсэн ажил Уургээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	Мэдлэг, туршлагаа хуваалцах чадвар	Ажилтны мэргэжил, ур чадварыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилт	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж асудал шийдвэрлэсэн байдал	Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл		
2													
3													

ДҮГНЭСЭН:

/албан тушаал/

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

Ур чадварын нэмэгдэл тооцох үнэлгээ, хувь хэмжээ

№	Нийт үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	90-100	25 хувь
2	80-89	20 хувь
3	70-79	15 хувь
4	60-69	10 хувь

## УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Газрын нэр.....

Хугацаа: .....

№	Шалгур үзүүлэлт	Ажил гүйцэтгэх чадвар			Ажлын арга барил				Нийт оноо, хувь
		1	2	3	4	5	6	7	
1	Ажилтны нэр	Авьяас билэг, мэргэжлийн ур чадвар, туршлагаа хөгжүүлж буудад угтэрлэн, түгээсэн байдал	Бүтээгч, шинэлэг санаачилга гарасан байдал, хэрэгжилт, ур дүн	Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил дутагдال гаргаагүй байх	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж асуудал шийдвэрлэсэн байдал	Ажлын гүйцэтгэлд гарсан ахиц, ур дүн,	Иргэд, байгууллагад узуулсэн төрийн үйлчилгээний чанар		
2									
3									

ДҮГНЭСЭН:

.....  
/албан тушаал/.....  
/гарын үсэг/.....  
/гарын үсгийн тайлал/

Ур чадварын нэмэгдэл тооцох үнэлгээ, хувь хэмжээ

№	Нийт үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	90-100	25 хувь
2	80-89	20 хувь
3	70-79	15 хувь
4	60-69	10 хувь

## УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

/Үйлчилгээний туслах ажилтан/

Хугацаа: .....

№	Шалгуур үзүүлэлт Ажилтны нэр	Ажил гүйцэтгэх чадвар			Нийт оноо, хувь
		1	2	3	
1					
2					
3					

ДҮГНЭСЭН:

...../албан тушаал/

...../гарын үсэг/

...../гарын үсгийн тайлал/

Ур чадварын нэмэгдэл тооцох үнэлгээ, хувь хэмжээ

№	Нийт үнэлгээ /оноо/	Ур чадварын нэмэгдлийн хувь
1	90-100	25 хувь
2	80-89	20 хувь
3	70-79	15 хувь
4	60-69	10 хувь

---xXx---